



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
 ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/105

Алтай хот

Хувийн хэвшил, Төрийн бус  
 байгууллагаар ажил гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, орон нутагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үйл явцыг иргэд, олон нийтэд сурталчилах, мэдээ мэдээллийг түгээх ажлыг "Их Алтайн Цадиг" ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР